



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/152

Хэрлэн сум

Зохион байгуулалтын арга  
хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Авто тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журам"-ын 2.1 дэх хэсэг, 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт болж буй цаг агаарын аюулт үзэгдэл (цасан шуурга хүчтэй салхилах)-ийн улмаас үзэгдэх орчин хязгаарлагдаж байгаа тул 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 13:00 цагаас 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07:00 цаг хүртэл түр хугацаагаар сум хоорондын болон сум доторх автозамын хөдөлгөөнийг хязгаарласугай.

2. Улаанбаатар - Өндөрхаан чиглэлийн А0501, Өндөрхаан –Бэрх чиглэлийн А19 дугаартай улсын чанартай автозамаар зорчих тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарт замын нөхцөл болон цаг агаарын нөхцөл байдлын талаарх мэдээлэл өгч санамж сэрэмжлүүлэг хүргэж ажиллахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн дэд хурандаа Э.Жавхлантагс)-д, Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д нарт үүрэг болгосугай.

3. Сумдаас гарах хөдөлгөөнд хяналтын пост ажиллуулж үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн бэлэн байдал, мэргэжлийн байгууллагатай харилцан ажиллаж мэдээ мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв гаргаж ажиллах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхийг Сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 2 дугаар ээлжийн хичээлийг цахимаар зохион байгуулж, үдийн дараа зохион байгуулагдах хичээлээс гадуурх үйл ажиллагааг хойшлуулан цахим хичээлийн ирц, хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавин ажиллахыг Боловсрол шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д, Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010379